
5.1. Эцэг эхийн системд бүртгүүлэх

Эцэг эхийн системд бүртгүүлэх

1. **http://parent.esis.edu.mn/** вэб хуудас руу орно.


2. Эцэг эхийн систем гарч ирнэ.



3.Нэвтрэх цонхны баруун дээд буланд байрлах БҮРТГҮҮЛЭХ товч дээр дарж шинэ хэрэглэгчийн бүртгэл цонх руу орно.


4.Талбаруудыг бөглөн, бүртгүүлэх товч дээр дарна.

а. **Утасны дугаар эсвэл Имэйл хаяг:** Эцэг эх өөрийн утасны дугаар эсвэл имэйл хаягаа оруулна. /Имэйл хаягаар баталгаажуулах код очих тул баталгаат имэйл хаягаа ашиглах/



5.Бүртгүүлсэн имэйл хаягт системийн хэрэглэгчийн бүртгэлтэй холбоотой имэйл очсон байна.

а. **Хэрэглэгчийн эрхийг баталгаажуулах код:** Тухайн кодыг хуулбарлан, хэрэглэгчийн бүртгэл баталгаажуулалтанд ашиглана.


Subject: Хэрэглэгчийн баталгаажуулалт

Шинэ хэрэглэгчийн баталгаажуулалт
Эрхэм хэрэглэгч танд энэ өдрийн мэнд хүргэе.
Та Боловсролын салбарын мэдээллийн системд хэрэглэгчээр бүртгэгдэх хүсэлт илгээсэн байна.
Та имэйл хүлээж авсанаас хойш 24 цагийн дотор доорхи кодоор баталгаажуулна уу.
544341
Танд баярлалаа.

Бидэнтэй холбоо барих:
Вэб сайт: https://parent.edu.mn
Имэйл: info@edu.mn

6. Эцэг/эхийн системээс илгээсэн имэйл-н **"Энэ линкээр**" холбоосон дээр даран, хэрэглэгчийн бүртгэл баталгаажуулах pop-up цонхыг дуудна.

а. **Нууц үг**


5.2. Эцэг эхийн системд нэвтрэх

5.2. Эцэг эхийн системд нэвтрэх

1. http://parent.esis.edu.mn/ вэб хуудас руу орно.

2. Эцэг эхийн систем гарч ирнэ.

3.Нэвтрэх цонхны талбаруудад бүртгүүлсэн утасны дугаар эсвэл имэйл хаяг, нууц үгийг бөглөн нэвтэрнэ.



Анхаарах зүйл:

Хэрвээ та системд бүртгүүлээгүй бол 5.1. Эцэг эхийн системд бүртгүүлэх **заавартай танилцана уу!**

5.3. Эцэг эх сурагчийн мэдээллийг холбох хүсэлт илгээх

5.3.Эцэг эх сурагчийн мэдээллийг холбох хүсэлт илгээх

Анхаарах зүйлс:


-Эцэг, эх, асран хамгаалагчид өөрийн хүүхдийн мэдээлэлд хандах эрх авахын тулд Анги удирдсан багш руу хүүхэд холбох хүсэлт явуулна.

-Анги удирдсан багш тус хүүхэд холбох хүсэлтийг зөвшөөрч, цуцлах эрхтэй.

Хэрэглэгч өөрийн эрхээр http://parent.esis.edu.mn/ вэб хуудас руу нэвтэрч орсны дараа өөрийн хүүхдийн мэдээллийг оруулан, сургууль руу хүүхэд холбох хүсэлт явуулна.

1.+Хүүхэд нэмэх цэс рүү орж Суралцагчийн QR код болон Гараар шивэх аль нэг сонголтоор хүүхэд бүртгэх хүсэлт илгээнэ.

2.Хүүхдийн мэдээлэл талбаруудыг үнэн зөв бөглөнө.



<u>Анхаарах зүйлс:</u>

<u>-Тухайн нэг сурагчийн мэдээлэлд зөвхөн нэг эцэг, эхийн бүртгэлтэй эрхээр хандах боломжтой.</u>

<u>-Нэг эцэг, эхийн системийн эрхэнд олон сурагчийн мэдээллийг холбогдох боломжтой.</u>

<u>-Эцэг эхийн илгээсэн мэдээлэл нь системийн мэдээлэлтэй тохирсон тохиолдолд “Сурагчийн мэдээлэл холбох хүсэлт” амжилттай болно. */РД, эцэг/эхийн нэр, нэр/*</u>

<u>-Мэдээллийг кирилл үсгээр, юникод фонт ашиглан, үнэн зөв бөглөнө.</u>


<u>1. Хүүхдийн мэдээлэл оруулах хэсэгт дараах талбаруудыг бөглөнө.</u>

<u>-Та хүүхдийн хэн болох</u>


<u>-Регистрийн дугаар</u>

<u>-Эцэг/эхийн нэр</u>

<u>-Нэр</u>



<u>2. Суралцагчийн QR кодыг уншуулж хүүхдээ холбох боломжтой.</u>



_


5.4. Эцэг эхийн хүүхэд холбох хүсэлт шийдвэрлэх

5.4. Эцэг эхийн хүүхэд холбох хүсэлтийг шийдвэрлэх

Анхаарах зүйлс:

1. Эцэг, эх, асран хамгаалагчид өөрийн хүүхдийн мэдээлэлд хандах эрх авахын тулд Анги удирдсан багш рүү хүүхэд холбох хүсэлт явуулна.


2. Анги удирдсан багш тус хүүхэд холбох хүсэлтийг зөвшөөрч, цуцлах эрхтэй.



Суралцагчийн эрх Эцэг/эх үйл ажиллагаа идэвхжүүлэн сонгоход, тухайн АУБ-д ирсэн хүсэлтүүдийн жагсаалт харагдана.

Хүсэлтийн жагсаалтаас Бүлэг, Суралцагчийн овог, нэр, Регистрийн дугаар, суралцагчийн төлөв, хүсэлт илгээгчийн овог, нэр, Регистрийн дугаар, хүсэлт илгээсэн огноо, хүсэлтийг шийдвэрлэсэн төлөв зэрэг мэдээллүүдийг харах боломжтой.

Хүсэлтийн жагсаалтын ард байрдах "Дэлгэрэнгүй" товчин дээр даран, хүсэлтийн дэлгэрэнгүй мэдээллийн цонхыг дуудна.



— Хүсэлтийг батлах - Тухайн хүүхдийн мэдээллийг хүсэлт явуулсан эцэг, эхэд харуулахыг зөвшөөрөх

— Татгалзах - Тухайн хүүхдийн мэдээллийг хүсэлт явуулсан эцэг, эхэд харуулахыг үл

5.5 Суралцагчдад QR код хэвлэх

Анги удирдсан багш суралцагчдад QR код хэвлэх зааварчилгаа

Анги удирдсан багш суралцагчдад QR код хэвлэн олгохын тулд:

1. Багшийн системүү өөрийн эрхээр нэвтрэн орно.

2. Эцэг, эх холбох хүсэлт модулийг сонгоно.

3. QR код хэсэгт харагдаж буй суралцагчдийн кодыг хэвлэх товч даран хэвлэнэ.

- **Багшийн системүү өөрийн эрхээр нэвтрэн орно.**




Нэвтрэх нэр

Нууц үг


Нэвтрэх

© 2021 БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ

- **Эцэг, эх холбох хүсэлт модулийг сонгоно.**



- **<u>QR код хэсэгт харагдаж буй суралцагчдийн кодыг хэвлэх товч даран хэвлэнэ.</u>**



5.6 Суралцагчидийг QR кодоор нэвтрүүлэх заавар

Нийгмийн ажилтан болон жижүүр багш нар ESIS системийн гар утасны апплекэйшн ашиглан суралцагч болон ажилчдын эрүүл мэндийг QR кодоор шалган сургуульд нэвтрүүлнэ. Ингэснээр суралцагчид, багш ажилчдыг Коронавирусээс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

1. Нэвтрэх үйл ажиллагааг дараах алхамчилсан дарааллын дагуу хийнэ.

1.1 Сургалтын байгууллагын тандалтын баг нь мобайл төхөөрөмж дээр ESIS апликейшнийг татаж суулгасан байна.
2.2 Тандалтын багийн нэвтрэх бүртгэл хөтлөх системийн хэрэглэгчийн эрхийг Аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтсээр дамжуулан хүргүүлнэ.

1. Нийгмийн ажилтан болон жижүүр багш нэвтрэх нэр, нууц үгээр ESIS апплекэйшнээр хандан орно.

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ

Та хэрэглэгчийн нэр, нууц үгээ ашиглан системд нэвтэрнэ үү. Үндсэн нүүр рүү буцах бол доорх товчийг дарна уу.

Багшийн код
es3910111423


Нууц үг
••••••••

СИСТЕМД НЭВТРЭХ

© 2021 БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ

75778080


2. Бүртгэл хийж буй байршлаа сонгож өгнө.




2. Нэвтрэх үйл ажиллагааны бүртгэл нь 2 сонголттой байна.

QR код уншуулахад Хэвийн эсвэл Сэжигтэй гэсэн 2 сонголттой байна.

2.1.1 Суралцагч ямар шинж мэтдэггүй бол хэвийн товчийг дарж сургууль руу нэвтрүүлнэ.



2.1.2 Суралцагч ямар нэгэн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд Сэжигтэй товчийг дарж дараах талбарыг бөглөж хариу авсан арга хэмжээг сонгоно.




2.2 Үнэмлэхгүй товчийг дарж ороход Суралцагчид болон Ажилчид гэсэн 2 цэснээс сонголт хийж бүртгэнэ.


2.2.1 Суралцагч цэсний анги бүлгийг сонгоход суралцагчдийн нэрс жагсаалтаар харагдана.

*** Нэвтрэн орох суралцагчийн халуун, биеийн байдлыг хянаж хэвийн эсвэл сэжигтэй гэсэн 2 сонголтоос сонгож бүртгэл хийнэ.**

*** Хэвийн товч дарахад амжилттай бүртгэлээ гэсэн мессэж гарна.**




<u>* Суралцагчийн биеийн байдал халуунтай нөхцөлд сэжигтэй гэсэн товчийг дарж талбарыг бөглөж хариу авах арга хэмжээг сонгож бүртгэлийг хийж эцэг эхэд нь хүлээлгэн өгнө.</u>




3.2.2 Ажилтан цэсэнд багш, ажилчдын нэрс жагсаалтаар гарч ирнэ.

*** Нэвтрэн орох суралцагчийн халуун, биеийн байдлыг хянаж хэвийн эсвэл сэжигтэй гэсэн 2 сонголтоос сонгож бүртгэл хийнэ.**

*** Хэвийн товч дарахад амжиллтай хадгалагдлаа мессэж гарна.**



<u>* Багшийн биеийн байдлыг хянаж халуунтай нөхцөлд сэжигтэй гэсэн товчийг дарж бүртгэлийг хийж Гэрт буцаах эсвэл Эрүүл мэндийн байгууллагад хандана.</u>



2. Тандалтын баг нь суралцагчдийн өдрийн ирцийн бүртгэлийг дараах алхамчилсан дарааллын дагуу бүртгэнэ.

Нийгмийн ажилтны эрх нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- **Хянах самбар**
- **Ирцийн бүртгэл**
- **Тайлан**
- **Эрүүл мэндийн асуумж**

Хянах самбар нь тухайн сургуулийн хичээллэсэн өдрүүдийг сонгож ирцийн мэдээллийг график байдлаар харуулна.

09/06 Даваа гараг

Хянах самбар | Ирцийн бүртгэл | Тайлан | Эрүүл мэндийн асуумж

Хянах самбар


Есөнбулаг сумын 1-р сургууль | 2020-11-02 | Хайх

Тусла


Ирцийн нэгтгэл




Боловсролын түвшнээр



Хичээллэх ээлжээр



Ангиар



Ирцийн бүртгэл.
Өдрийн ирцийг дараах байдлаар бүртгэнэ.

Вэб болон Мобайл апликэйшн ашиглан бүртгэнэ.

Анхаарах зүйл нь: Өдрийн ирцийг нөхөж бүртгэх боломжгүй.